

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Дарам-Очир	Дугаар	L260
Оршин суугаа аймаг	Төв аймаг	Оршин суугаа сум	Баянцагаан сум
Төрсөн газар	Баянцагаан сум	Төрсөн он	1931
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Бамбар Эрдэнэ ламын хүрээ, Дэлгэр Өлзийтийн хурал, Амгалангийн хурал	Сүм хийдийн дугаар	ТӨСЭ 064, ТӨБЦ 008, ТӨБЦ 001, ТӨБЦ 007
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-рсарын 14	Ярилцлага авсан хүн	Жужа

Сэргэлэн сумын Бамбар эрдэнэ ламын хүрээ, Баянцагаан сумын Дэлгэр Өлзийтийн хурал, Өвөр гурван жас Жужа: Ингээд Өвөр гурван жасын тухай ярьж өгнөүү ? Хэдэн дугантай байсийм хэдэн ламтай байсийм бэ ?

Дарам – Очир: Ганцхан дугантай тогтмол хурал байхгүй тиймээс лам нар байхгүй. Ганц тахилч л байна зул хүжийг нь асаагаад бурхан тахилыг нь харж хандаж байдаг. Зуны цагт лам нар Чойроос ирнэ, хүрээнээс ч гарч ирнэ, Бамбар эрдэнийн хүрээнээс ч ирнэ тэгээд хурал хурдаг байсан энэ Баян сумын нутагт Хажуу гэдэг газар.

Жужа: Нэг дуган нь модон дуган байсануу , тоосгон дуган байсан уу?

Дарам- Очир: Дуган ч гэж гонхон гэж ганц жижиг модон байшин байсийм тэнд бурхан тахилаа хадгална

Жужа: Тахидаг овоо байсан уу?

Дарам- Очир: Тэрүүхэн баруун талд нь нэг овоо байсан юм. Эрэвгий хар өндөр овоо гэж нэртэй овоо байсийм.

Жужа: Одоо бригадын жасын тухай асууя? Хэдэн жас хэдэн дугантай байсан бэ ?

Дарам- Очир: Бригадын жас нэг л дугантай байсан тав зургаа үгүй арваад тооны лам байсан байх

Жужа: Тогтмол хуралтай байсан уу ?

Дарам- Очир: Тогтмол хуралтай байсан ухаантай юм.

Жужа: Ямар шүтээн сахиустай байсан юм бэ ?

Дарам- Очир : Мэдэхгүй

Жужа: Хамба нь хэн гэж хүн байсан юм бэ ?

Дарам- Очир: Доохүү гэж байсан.

Жужа: Нэг дуган нь модон дуган байсан уу тоосгон дуган байсан уу ?

Дарам- Очир: Аа нэг модон ч биш тоосгон ч биш гэр маягийн тийм шовгор мод босгодог тэгээд хурал хурахаараа дээгүүр нь даавуу нөмөргөөд л хурна .

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жужа: Ямар овоо тахидаг байсийм бэ ? Тэр баруунтай нь Мандал гэдэг овоог тахидаг байсан уу ?

Дарам- Очир : Тийм Мандалын овоог тахидаг байсан

Жужа: Хүйсийн хурал гэж хаана байсан бэ ?

Дарам- Очир: Энүүхэн энд байсан ялгаагүй тогтмол суудаг лам байхгүй. Лувсан хорол дархан гэж хүн манаж байсийм

Жужа: Мод болон тоосгон дуган байсан уу?

Дарам- Очир: Ялгаагүй ээ ийм дугантай газар ерөөсөө байгаагүй

Жужа: Суварга байсануу ?

Дарам – Очир: Эдгээр жасуудад ерөөсөө суварга байгаагүй харин Агуйтын жасад л нэг суварга байсан одоо энэ Төв аймгийн Баян сүмн нутагт. Харин би Бамбар эрдэнийн хүрээний талаар арай илүү мэднэ тэрнийгээ ярья. Одоо энэ хойно Эрээдэнгийн цагаан овооны хажууд Цагаанчулуут гэдэг газар байсийм .

Жужа: Хэдэн дуган сүмтэй байсан бэ ?

Дарам – Очир: Цогчин , жүд , манба , гүнрэг гэсэн 4 дуган, хойт сүм баруун сүм гүдэнгийн сүм / түрүүчийн лам нарын шарилыг оршуулдаг / ийм гурван сүмтэй , 2 суварга , совх гэдэг 1 байшин одоо сор залдаг юмуудаа , байнгын 300- аад лам суудаг ийм байсан.

Жужа: Хамба нь хэн гэж хүн байсан бэ ?

Дарам- Очир: Хамгийн сүүлчийн хамба Жигмэд гэлэн гэж хүн сууж байгаад хаагдсан.

Жужа: Та тэнд сууж байсан уу ?

Дарам- Очир: Би тэнд сууж байсан тийм болоод сайн мэдэж байна

Жужа: Хэдэн наснасаа хэдэн нас хүртлээ суусан бэ ?

Дарам- Очир: 7 наснаасаа 17 нас хүртэл хаагдтал нь 38 он хүртэл байсан . Хаагдахаасаа өмнө нь 2 дуган нь шатчихсан юм бас.

Жужа: Дуганууд нь юугаар хийсэн бэ модооруу тоосгоор уу ?

Дарам- Очир: Дандаа модон дуган байсан

Энхбаяр: Давхар дуган байсан уу дээшээгээ ?

Дарам – Очир : Байхгүй ээ дан дан дуганууд байсан .

Энхбаяр: Гэр хэлбэрийн дуган байсан уу?

Дарам- Очир: Байхгүй

Жужа: Ямар овоог тахидаг байсан бэ ?

Дарам- Очир: Эрээдэнгийн овоо зүүн урьд нь байдаг мөн өмнө нь байдаг эмээгийн овоог тахина. Эмээгийн овоог тахиж наадам хийнэ энд тал талаас морьд их ирнэ сайхан наадам хийдэг байсан . / Хүрээний сүм дуган суварганы байршлыг хоорондоо ярилцан бүдүүвч зургаар зурж гаргав бололтой /

Жужа: Ямар сахиус шүтээнтэй байсан юм бэ ?

Дарам- Очир: Жамсран сахиус шүтдэг байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жужа: Суварганууд хаанаа байсан бэ ?

Дарам- Очир: Зүүн хойно нь нэг , баруун хойно нь нэг онцгой тусдаа ийм хоёр суварга байсан.

Жужа: Хүрээний ойролцоо ямар худаг ус байсан бэ ?

Дарам- Очир: Тэрүүхэн баруун хажууд нь гүнжийн худаг , өмнө талд нь уяан худаг гэж ийм 2 худаг байсан.

Жужа: Лам нар нь хаана суудаг байсан бэ?

Дарам-Очир: Зүүн хойт хүрээ , зүүн хүрээ , баруун хүрээ гээд 3 хэсэг газар суудаг байсан олон эгнээ гудамжууд байдаг

Жужа: Лам нараас өөр хүн хүмүүс амьдрах уу, эсвэл зөвхөн лам нар суух уу?

Дарам- Очир: Үгүй зөвхөн лам нар сууна.

Жужа: Гороо хашаа байсан уу ?

Дарам-Очир: Байгаагүй , байшингуудтай байшингуудынхаа өмнө гэрээ бариад гудамлаад эгнээлээд

Жужа: Жас байсан уу ?

Дарам-Очир: Байсан. Их жас нь зүүн урьдаа, цогчин жас ялгаагүй тэндээ, жүдийн жас баруун урьдаа, гүнрэгийн жас нь баруун хойноо, мамбын жас зүүн хойноо

Жужа: Бүрээний шат байсан уу ?

Дарам-Очир: Байсан тэр урьд өмнөд голдоо. 14 гишгүүртэй нилээд өндөр юм байсан нилээд онцгой, бүрээ шатны хоёр талд 2 чоги мод гэж юм байсан орой дээрээ юутай одоо энэ сүм дуганын орой дээр байдаг шиг

Жужа: Ямпай байсан уу ?

Дарам-Очир: Ямпай байгаагүй.

Жужа: Хувилгаан лам гэж байсан уу ?

Дарам-Очир: Бамбар эрдэнэ лам гэж хувилгаан лам байсан

Жужа: Хамгийн сүүлчийнх нь хэддүгээр дүр нь байсан бэ ?

Дарам-Очир: 5-р дүрийн л хувилгаан байсан болов уу.

Жужа: Энэ лам хамба нь байсан уу ?

Дарам-Очир: Үгүй ээ жаахан хүүхэд шүү дээ. Бамбар эрдэнэ хувилгаан ламын дүр гээд . Хамгийн сүүлчийн хамба нь Жигмэд гэлэн гэж л хүн байсан.

Жужа: Энэ хүрээ хуучин засаг захиргааны хуваарийн дагуу Түшээтхан аймагт орохуу Цэцэнхан аймгийнх уу ?

Дарам-Очир: Үгүй ээ биш Богдын шавийн нутаг байсан.

Жужа: Тэнд цам харайдаг байсан уу ?

Дарам-Очир: Үгүй цам харайхгүй Чойрт л цам гардаг байсан

Жужа: Майдар эргэх үү ?

Дарам-Очир: Эргэнэ. хаврын дунд сард юмуу даа 5 –р сард л эргэдэг байсан

Жужа: Ганжуур эргэх үү ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дарам-Очир: Эргэхгүй. гэхдээ ганжуур данжуурын ном байдаг. Ганжуурын 120 боть , данжуур гээд тэрүүгээр хурал хурна

Жужа: Хайлан аль дуганд хурах вэ?

Дарам-Очир: Жүдийн дуганд. Цогчингийн баруунтай .

Жужа: Хайланд хэдэн лам хурах вэ?

Дарам-Очир: Өө тэр мэдэхгүй. Багцаагаар 20, 30, 40-өөд юм байсан байлгүй

Жужа: Гэлэн лам олон байсан уу ?

Дарам-Очир: Олон олон ер нь дандаа л гэлэн байсан юм шүү. гавьж ерөөсөө байхгүй .

Жужа: Сор залах уу ?

Дарам-Очир: Сор зална. өвлийн сүүл сарын 29 –нд хангал хурж дуусаад сор зална бас зуны дунд сарын 29 –нд сор зална .

Жужа: Энэ 2 сор адилхан байсан уу ? Ондоо байсан уу ?

Дарам-Очир: Адилхан адилхан харин уншдаг ном нь өөр байсан байх .

Жужа: Нүгнээ сахих уу ?

Дарам-Очир: Сахинаа нүгнээ сахина. Хавар 5-р сарын дундуур ойролцоогоор сахина.

Жужа: Бамбар эрдэнэ хувилгаан өөрөө монгол хүн үү. төвд хүн үү ?

Дарам-Очир : Монгол хүн монгол хүн. Бамбар эрдэнэ хувилгаан энэ манай Цагаанчулуутын хүн.

Жужа: Энд төвдөөс, Богдын хүрээнээс лам нар ирдэг байсан уу ?

Дарам-Очир: Төвдөөс ирэхгүй Богдын хүрээнээс хааяа лам нар ирнэ. Бамбар эрдэнэ хувилгааныг чинь 5 настай байхад нь Номт гэдэг газраас залж авчирсан юм.

Жужа: Таниас өөр энд сүүж байсан настай лам нар одоо бий юу ?

Дарам-Очир: Ер нь байхгүй болсон байх ганц нэг юм байсан үхээд дууссан бололтой

Жужа: Одоо тэр хийдийг сэргээсэн үү ?

Дарам-Очир: Үгүй.Бүр тэр хойно хаа хамаагүй газар нэг их олон суварга босгочихоод байгаа. Баян сумын төвд нэг жижиг дуган босгосон юм гэсэн.

Жужа: Тэр их олон суварга уу?

Дарам-Очир: Тийм тийм тэр сэргээж байгаа царай нь юм гэнэ лээ. Баян сум ламгүй болчихоод байгаа юм гэсэн хааяа хааяа хотоос лам нар очиж хурал хурдаг гэсэн

Жужа: Солхын дуганд ямар хурал хурдаг байсан юм бэ ?

Дарам-Очир: Дуган бишээ ганц байшин байсан юм. Тэнд орой болгон л сахиус тахина гээд юм болдог байсан одоо бодоход энэ бөөгийн талын юм байсан юм болов уу .

Жужа: Энд лүйжин тавидаг лам нар байсан уу ?

Дарам-Очир: Байгаагүй. Лүйжин тавидаг лам нар ерөөсөө байгаагүй.

Жужа: Авгайтай лам нар байсан уу ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дарам-Очир: Байгаагүй ээ энд тийм юм байх ёсгүй байсан гэвч цаагуураа юу болж байсан юм мэдэхгүй.

Жүжэ: Хятад наймаачид ирдэг байсан уу?

Дарам-Очир: Аа зөндөө ирдэг байсан. Хятадууд нэг гэрт нь сууж байсан.

Энхбаяр: Хятадуудтай харилцаа ер нь хэр байсан юм?

Дарам-Очир: Хятадуудтай юу, үгүй ээ би яаж мэдэхэв дээ. Тэнд байгаа лам нар нь л Хятадуудыг л хөөхгүй л байсан байх. Хошуу шиг байна биз гээд л зүгээр ганц нэг гэртэй мэртэй явдаг л байсан. Тийм том пүүс бол байгаагүй. Улааны пүүс гэж нэг наана байсан юм.

Жүжэ: Баянцагаан сумын нутагт байгаа Дэлгэр Өлзийтийн хурлын талаар сонссон уу? Хөтөл нуурын тэнд байгаа?

Дарам-Очир: Дэлгэр Өлзийтийг мэднэ. Жаахан л юм байсан юм.

Энхбаяр: Хэдэн дугантай?

Дарам-Очир: Ганц л байшинтай.

Жүжэ: Хэдэн ламтай?

Дарам-Очир: Лам байхгүй ээ, ганц л лам сахиж байсан юм.

Жүжэ: Лам нар зуны үеэр ирдэг байсан уу?

Дарам-Очир: Өө ялгаа байхгүй ээ, тэр нэг л үед нэг хурал хурдаг юм ш дээ, тэгэхээр нь л ирнэ.

Жүжэ: Энэ Баянцагааны нутаг Богдын шавь нарын газар уу?

Дарам-Очир: Баянцагаан Богдын шавь аа, Богдын шавь.

Энхбаяр: Тэгээд энэ аль овоогоо тахидаг байсан, Дэлгэр Өлзийт?

Дарам-Очир: Дэлгэр Өлзийтийн овоогоо тахина.

Энхбаяр: Аль талд нь байдаг овоо юм?

Дарам-Очир: Энэ баруун хойд талд нь.

Энхбаяр: Тэгээд энэ Дэлгэрийн Өлзийтийн ус нь хаанаа байсан юм?

Дарам-Очир: Дэргэдээ, дэргэдээ худаг байсан юм. Одоо ч бий.

Энхбаяр: Аль талдаа?

Дарам-Очир: Зүүн, жасынхаа зүүхэнд.

Жүжэ: Тэр газар эндээс аль тийшээ, хэдэн км вэ?

Дарам-Очир: Баруунтаа арван хэдэн км л байна.

Энхбаяр: Дэлгэр Өлзийтийн хурлын тэнд Амгалангийн хурал гэж байна. Өлзийтийн хурал гэж байгаа из дээ?

Дарам-Очир: Тийм, арагшаа байгаа.

Энхбаяр: Өлзийтийг чинь тэгвэл Амгалангийн хурал гэж байгаа юм байна?

Дарам-Очир: Амгалангийн гол гэдэг юм. Амгалангийн жас гэж байдаг юм.

Энхбаяр: Та Амгалангийн жасыг, мэдэх үү, бас л нэг дуган?

Дарам-Очир: Бас л нэг.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Энхбаяр: Овоо нь?

Дарам-Очир: Овоо нь Баруун босго гэж овоог тахина.

Энхбаяр: Баруун талдаа байдаг юм уу?

Дарам-Очир: Наанаа, зүүн талдаа байдаг юм.

Жужа: Худаг гол?

Дарам-Очир: Худаг ус нэг...ганц худагтай даа.

Энхбаяр: Аль талдаа?

Дарам-Очир: Жасынхаа зүүн өмнө.

Энхбаяр: Амгалангийн гол гэдэг газар уу?

Дарам-Очир: Тийм.

Энхбаяр: Энэ Дэлгэр Өлзийтийн хурал чинь Дэлгэр Өлзийтийн овоо гэдэг газар байгаа юу, тийм ээ?

Дарам-Очир: Тийм.

Энхбаяр: Найдан жасын тухай?

Дарам-Очир: Мэдэхгүй байна.

Жужа: Цавчир?

Дарам-Очир: Цавчир багшийн минь байдаг газар байсан. Одоо юу ч байхгүй.

Энхбаяр: Цавчирын хөндий чинь эндээс хаанаа байгаа билээ?

Дарам-Очир: Зүүн урагшаа, зүүн өмнөө.

Энхбаяр: Хэдэн км?

Дарам-Очир: Цавчир одоо энэ хавьд арваад км байна.

Жужа: Тэнд ганц дуган байсан уу?

Дарам-Очир: Ганц байсан.

Жужа: Тахидаг овоо ямар овоо байсан?

Дарам-Очир: Батын овоо тахидаг байсан . Бат гэж овоог тахидаг байсан, одоо ч тахиж байгаа. Одоо тахихаа байчихсан юм шиг байна лээ дээ.

Энхбаяр: Тэнд ямар ч туурь байхгүй юу?

Дарам-Очир: Ямар ч туурь байхгүй. Би сайн мэдэж байна. Ганц хэлтэрхий шороо ч байхгүй.

Энхбаяр: Худаг нь хаана байна?

Дарам-Очир: Тэр голдоо байсан, гол гэж манайхан нэрлээд байгаа юм.Гол гэхээр юм байхгүй, нэг жаахан шүүдүүрхүү л юм байхгүй юу. Тэрэн дотор л нэг худаг байсан. Ламын хүрээн дээрээс лам сүраглавал манай суманд нэг Дамдинчойдорж гэж хүн бий. Энэ хоёрдугаар багт.Тэндээс асууна даа. Өө хэн байна ш дээ, Баян суманд Сономоолувсандорж гэж нэгдлийн холбооны дээд зөвлөлийн орлогч дарга энэ тэр явсан. Сономоолувсандорж гэж ламын хүрээний хүн, ламын хүрээний түүхийг надаас ч илүү мэдэж магадгүй, сэргэлэн.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Энхбаяр: Энэ хаана байгаа гэлээ?

Дарам-Очир: Одоо УБ хотод шар хад хавьцаа орон сууцанд байгаа.

Энхбаяр: Одоо лам уу?

Дарам-Очир: Үгүй ээ, одоо юу байхав.

Энхбаяр: Энэ Зүлэгтэйн жас гэж сонссон уу?

Дарам-Очир: Өвөр Зүлэгтэйн жас.

Энхбаяр: Тийм, та бүгдийг нь мэдэж байна ш дээ / инээв /

Дарам-Очир: Сүүлийн үед Өвөр зүлэгтэй гэдэг газар байсан юм. Энэ зууртаа худагтай.

Энхбаяр: эндээс аль зүгт байна?

Дарам-Очир: Зүүнтээ холриод км л байх, Багцаа ч үгүй дээ.

Энхбаяр: Овоо?

Дарам-Очир: Овоо байхгүй. Өвгөн сайхан овоо гэж тэр зууртаа овоо байсан юм.Тэр овоогоо тахиж байсан юм.

Одоо ч тахиж байгаа.

Жужа: Ганц дугантай юу?

Дарам-Очир: Ганц аа ганц. Дуган ч гэж дээ, энэ жасууд чинь дандаа байшин. Тэр Ламын хүрээ чинь л дугануудтай байсан юм. Ламын хүрээний лам нарыг сайн мэдэх бас нэг хүн байгаа юм байна шүү. Хэнгэрэг гэж одоо лам байгаа.

Энхбаяр: Аль хийдийн лам бэ?

Дарам-Очир: Тэр Шар хаданд урдүүр нэг...Хэнгэрэг.

Энхбаяр: Эмнэлгийн хийд юм уу?

Дарам-Очир: Эмнэлгийн эмч нар, замаар явж байгаад нэг сүм дээр очдог юм байна. Их захаас өнгөрөөд Нарантуул захаас өнгөрөөд, офицеруудын ордноос өмнө...

Энхбаяр: Нарантуул захын яг энэ талд байдаг уу?

Дарам-Очир: Тийм, тэрний хойхно байдаг юм.Тэнд байдаг юм.

Энхбаяр: Бамбар Эрдэнэ ламын хийдээс өөр ондоо хийдүүд байсан уу?

Дарам-Очир: Байхгүй ээ, байхгүй. Энэ хойхно Баргын хурал гэж байсан юм. , Хөлөнбуйраас баргууд түлхэж нүүж ирсэн байгаа юм. Тэгээд тэндээ нэг сүм байгуулаад, их баян барга нар. Тэгээд тэндээ шингэсэн юм даа. Одоо ихэнх нь амьд сэрүүн байна даа. Ганцхан дугантай. Харин байшин биш, дуган байсан юм шүү, Баргын дуган чинь.Баргын дуган л гэдэг байсан даа.

Жужа: Ямар нэртэй газар байсан бэ?

Дарам-Очир: Баргын дуганы юу, аа мэдэхгүй. Баргын дуган л гэдэг байсан даа.

Жужа: Хэдэн лам байсан бэ?

Дарам-Очир: Аа нэг арваад лам байсан байх шүү.

Энхбаяр: Лам нар нь энэ нутгийн лам нар байсан юм уу, баргаасаа ирсэн лам нар?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дамар-Очир: Баргаасаа ирсэн лам нар.

Энхбаяр: Өвөрмонгол биш биз дээ?

Дамар-Очир: Биш. Хөлөнбуйраас чинь Балдан шалбаалин гэж нэг хошуу юм уу даа, наашаа нүүсэн гэж байгаа юм. Тэгээд өнөөдүүл нь хойноос нь явуулахгүй гээд байсан.Тэгээд яаж ч чадаагүй алдчихсан юм гэнэ лээ.Тэгээд энд шингэчихсэн.

Энхбаяр: Энэ Баргын овоо гэж юу юм бол?

Дамар-Очир: Цаньдагийн овоо гэсэн байх аа. Буруу байж магадгүй шүү.

Энхбаяр: Бөхөгийн хурал гэж сонссон уу?

Дамар-Очир: Бөхөг өө, үгүй тэр Богдын үед байсан юм байгаа биз?Би мэдэхгүй.

Энхбаяр: Бөхөг гэж гол сонсоогүй юу?

Дамар-Очир: Үгүй.

Жужа: Та Богдын хүрээнд очиж үзсэн үү?

Дамар-Очир: Үзсэн, жаахан байсан. Энэ жасуудад ч үзсэн, жоохон байсан. Богдын хүрээний цогчин гэсгүй Гомбодоо гэдэг эндхийн хүн байсан юм. Түүх их сонин юм байгаа юм. Гомбодоо гуай чинь намын хорооны дарга байсан юм байна лээ ш дээ. Баригдаад долоо хоног болсон чинь баригдах биш нөгөө ямар лам нар барихаа бичиж өгчихөөд, тэгээд өөрийнхөө хамаатан садан бүгдийг нь өгсөн байгаа юм ш дээ. Одоо энэ Өлзий, Гончигзов гээд хэдэн улсууд байсан юм. Өөрийн шавь нар ч юм уу, хадам ч юм уу. Зайсангийн Баяр гэж манай энд намын үүрийн дарга байсан юм. Тэр маршал Чойбалсангаас даалгавар аваад Дорнодоос мориор давхиад ганц ч буулгүй, өдөр шөнө хоёр давхиад ирж байсан гэж байгаа юм. Тэгэхэд улсаас явж байсан гэдэг юм , өөрөө. Тэгээд сүүлд л маршал Чойбалсан аваачсан л даа. Их айхтар хүн байсан, ер нь их зальтай хүн байсан даа. Их зэрлэг байсан юм гэнэ лээ, тэр дөнгөө гэдэг чинь. Ихээхэн юм зааж өгнө ш дээ, бага байхад. Ийш тийшээ явахдаа хоёр морьтой явж бай. Ижилсээд хоёулаа сайхан байдаг юм энэ тэр гээд.

Энхбаяр: Бамбар Эрдэнэ ламын хүрээ гээд байна ш дээ, тэнд чинь хамба лово, цорж гээд байсан уу?

Дамар-Очир: Хамба гэж байсан. Ловон гэж байхгүй, цорж гэж байхгүй.

Энхбаяр: Унзадууд байх уу?

Дамар-Очир: Унзадууд байна. Ширээт лам гэж байна. Одоо ухаандаа цорж л юм даа. Дондогдорж, миний багш байсан Цэдэнсодном гээд Дойдоо энэ тэр гээд байсан юм.

Энхбаяр: Хэдэн гэсгүйтэй байсан юм?

Дарам-Очир: Өө дацан бүр нэг гэсгүйтэй. Цогчин хоёр гэсгүйтэй.

Энхбаяр: Энэ зайдан, даамал лам энэ тэр гэж байсан уу?

Дарам-Очир: Байхгүй ээ.

Энхбаяр: Ном барладаг байсан уу?

Дарам-Очир: үгүй, ном хэвлэхгүй, номын бархан байхгүй. Бамбар Эрдэний хүрээ чинь лам ихтэй юм болохоор хувилгаан аймаг гээд хотод бий ш дээ.Тэндээ очоод хурлаа хурна. Хэрэгтэй юмаа авна. Тийм байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жужа: Энэ Гочоо аймгийн хувилгаан дуган нь ямар дуган байсан бэ?

Дарам-Очир: Аа нэг хоёр дуган л байсан даа. Тэрнийг ч сайн мэднэ.

Энхбаяр: Энэ Бамбар Эрдэнэ гэсэн нэрнийх нь тухай та хэлээд өгөөч, сонссон юм байвал?

Дарам-Очир: Энэ Арын долоон хутагт гэж байсан юм гэнэ лээ. Тэр Бамбар Эрдэнэ лам Арын долоон хутагтын нэг нь л юм байгаа биз. Тэр дээд лам нь баригдаад, хамгийн сүүлийн лам нь энэ Чойроос ингээд хамгийн эхнийх нь Бамбар Эрдэнэ ламын эндээс ингээд өөрснийгөө тодруулдаг байсан юм байна лээ. Лам нар мэргэлээд л , эдэлж хэрэглэж байсан зүйлийг нь бас тэгээд л...

Жужа: Та энэ Мандширын хийдэд очсон үү?

Дарам-Очир: Мандширын хийдэд үү, үгүй ээ. Би Мандширын хийдэд очиж үзээгүй.

Энхбаяр: Энэ Бамбар Эрдэнэ ламын хийд анх хэдэн онд байгуулагдсан бол? Хэд орчим настай хийд байсан юм бол?

Дарам-Очир: 1930-аад оны үед л наян тавны ой болж байсан юм даа. Наян тавны ой болж байгаа гээд ташлим аравнай гэдэг хурал хурж байсан юм.

Энхбаяр: Ташлим аравнайгаа хэд хоног хурж байсан юм?

Дарам-Очир: Гурав хоног л уншсан.

Энхбаяр: За боллоо, Аягүй их юм ярьж өглөө та.